


БИДНИЙ АЖИГЛАЛТАД БҮЙ ХУВЬЦААНУУД

ГОЛОМТ КАПИТАЛ:

ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА,
СУДАЛГААНЫ ГАЗАР

(1-р хэсэг)





RioTinto

Reuters зорилтот ханш:
USD 81.7 (+28%)

Зөвлөмж:
Авах

RIO TINTO PLC нь Их Британид төвтэй уул уурхайн компани юм. Нийт 35 оронд 57,000 гаруй ажилтантайгаар төмрийн хүдэр, зэс, хөнгөн цагаан олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ба борлуулалтын талаас илүү хувийг БНХАУ-аас бүрдүүлдэг.

“Нийт 5 шинжээчийн 4 нь **АВАХ** зөвлөмж өгч буй бөгөөд зорилтот доод ханш 56.9 USD, дундаж ханш 81.75 USD байна.”

Хувьцааны ханшийн техник шинжилгээ:



Техник шинжилгээ:

- Богино хугацааны трендийн хүчийг илэрхийлэгч MACD индексийн индикаторууд унаж буй нь **богино хугацаанд уналт ахиад байж болохыг илтгэж байна.**
- Трендийн хүчийг илэрхийлэгч ADX индикатор 2021 онд 45.5 байсан бол одоо 13.0 болж буурчээ. Энэ нь **2021 оноос хойшхи уналтын трендийн хүч суларч буйг илтгэж байна.**

Хувьцааны ханшийн өсөлтөд нөлөөлөх суурь хүчин зүйлс:

- Уул уурхайн салбарын 152 компани биржид бүртгэлтэй байгаагийн 26 нь ногдол ашиг тараадаг ба Рио Тинто нь сүүлийн байдлаар 6.9%-ийн ногдол ашгийг тарааж байна.
- Рио Тинто компанийн үнэ орлогын харьцаа 1.5 байгаа нь түүхэн 5 жилийн дунджаасаа 11% доогуур байна.
- 2024 онд Дэлхийн улс орнуудын эдийн засаг 2023 оноос хойш сайжрах хүлээлтийн индекс өссөн нь эдийн засаг сэргэх, түүнд шаардлагатай гол түүхийг эд бүтээгдэхүүнүүдийн үнэ өсөх хүлээлтийг бий болгоод байна.




RioTinto



Reuters зорилтот ханш:
USD 81.7 (+28%)

Зөвлөмж:
Авах

Ногдол ашгийн өгөөжийн түвшин (ам.доллараар):



Рио Тинто компанийн 2023 оны борлуулалтын орлогын задаргаа:



Рио Тинто нь 2023 онд 54.04 тэрбум ам.долларын борлуулалтын орлоготой, 10.02 тэрбум ам.долларын цэвэр ашигтай ажилласан ба орлогын 60%-ийг БНХАУ-аас, 14%-ийг АНУ-аас бүрдүүлсэн байна.

Рио Тинто компани нь 2023 онд 54.04 тэрбум ам.долларын борлуулалтын орлоготой ажилласны 55% нь төмрийн хүдрийн борлуулалт, 22% нь хөнгөн цагаан, 12% нь зэсийн борлуулалтаас бий болжээ.

Рио Тинто хувьцааны ханш ба 62% агууламжтай төмрийн хүдрийн ханшийн хамаарал:





BYD CO. LTD.
SZSE: 002594
SEKH: 1211

Reuters зорилтот ханш:
HKD 299 (+42%)

Зөвлөмж:
Авах

BYD Company Ltd. нь БНХАУ-ын томоохон автомашин үйлдвэрлэгч компани. Компанийн үндсэн бизнес нь цахилгаан автомашин үйлдвэрлэл бөгөөд үүнээс гадна харилцаа холбооны төхөөрөмж, батарей ба фотовольтаик болон угсралт эвлүүлэлтийн бизнесүүд багтдаг.

- БНХАУ-ын Автомашин үйлдвэрлэгчдийн Холбооноос нийтэлсэн мэдээний дагуу 2023 онд тус улсад үйлдвэрлэсэн автомашины тоо өмнөх онтой харьцуулбал 11.6 хувь өссөн бол борлуулалтын тоо 12.0 хувиар өслөө.
- БНХАУ-ын автомашины экспортын хэмжээ борлуулалтын 16.32 хувийг эзэлж өмнөх онтой харьцуулбал 60 гаруй хувийн өсөлтийг үзүүлсэн байна.
- Нөгөө талаас БНХАУ-ын цахилгаан автомашины үйлдвэрлэл болон борлуулалт өмнөх жилтэй харьцуулбал тус тус 35.8 болон 37.9 хувийн өсөлтийг үзүүлж нийт үйлдвэрлэл болон борлуулалтын дүнгийн 3-ны 1-ийг эзэлж 9.6 болон 9.5 саяд хүрчээ.

Нийт 35 шинжээчийн 34 нь **АВАХ** зөвлөмж өгч буй бөгөөд зорилтот дундаж ханш 291.3 HKD байна.

Хувьцааны ханшийн техник шинжилгээ:

abliguan published on TradingView.com, Apr 11, 2024 14:17 UTC+8

BYD COMPANY LIMITED, 1W, HKEX 0196.0 H213.0 L195.3 C211.4 +13.5 (+6.82%)



2023 онд борлуулалтын орлого нь 602.3 тэрбум юань хүрсэн бөгөөд үүнээс 80.27 хувь нь цахилгаан автомашины сегменттэй холбоотой бол 19.68 хувь нь харилцаа холбооны төхөөрөмж, угсралт эвлүүлэлтийн үйл ажиллагаа болон бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэй хамааралтай байна.




Хувьцааны ханшид нөлөөлж болзошгүй суурь хүчин зүйлс:

- БНХАУ-ын Засгийн газрын бодлого, төрөөс олгож буй салбарын дэмжлэг өссөнөөр хувьцааны ханшид эерэгээр нөлөөлнө
- БНХАУ-аас бусад газраас нийт орлогын 26.6%-ийг бүрдүүлж байгаа ба бусад улс орнуудад бодлогын хүү буурснаар автомашины эрэлт нэмэгдэж ханшид эерэгээр нөлөөлнө
- БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн уналт, үл хөдлөх салбарын хямралын нөлөө арилснаар хувьцаанууд нийтээрээ өсөх хандлагыг үзүүлэх боломжтой.

Орлого, ашгийн үзүүлэлтүүд:


тэрбум юань

- Борлуулалтын орлого
- Нийт ашиг
- Цэвэр ашиг




Ашгийн голлох харьцаа үзүүлэлтүүд:


Хэдийгээр цахилгаан автомашины салбар дахь өрсөлдөөн нэмэгдэж, компаниуд үнээ бууруулах стратегийг 2023 оноос хойш баримтлаад байгаа ч BYD компанийн нийт ашгийн маржин 2021 оноос хойш өсөлттэй байна.




Томоохон хувьцаа эзэмшигчид



Балансын бүтэц



Борлуулалтын орлогын газарзүйн хуваарилалт





Golomt Capital
Delivering diversity



CITIC SECURITIES
HKEX: 6030

Reuters зорилтот ханш:
HKD 16.9 (+40%)

Зөвлөмж:
Авах, Хүлээх

CITIC Securities компани нь 1.3 их наяд юанийн хөрөнгөтэй БНХАУ-ын хамгийн том үнэт цаасны компани юм. Тус компани нь 1.5 их наяд юанийн бонд татан төвлөрүүлж, зах зээлийн 5.8%-ийг бүрдүүлсэн ба бондын зах зээлд 1-рт бичигдэж байна. Тус компани нь хөрөнгө оруулалтын банк, хөрөнгийн удирдлага, хувьцааны хөрөнгө оруулалтын үйлчилгээнүүдийг үзүүлдэг.

“Нийт 14 шинжээчийн 12 нь **АВАХ** зөвлөмж өгч буй бөгөөд зорилтот доод ханш 13.9 HKD, дундаж ханш 18.31 HKD байна.”

Хувьцааны ханшийн техник шинжилгээ:



Техник шинжилгээ:

- Богино хугацааны трендийн хүчийг илэрхийлэгч MACD индексийн индикаторууд унаж буй нь **богино хугацаанд уналт ахиад байж болохыг илтгэж байна.**
- Трендийн хүчийг илэрхийлэгч ADX индикатор 2021 онд 48.5 байсан бол одоо 27.4 болж буурчээ. Энэ нь **2021 оноос хойшхи уналтын трендийн хүч суларч буйг илтгэж байна.**
- Хөдөлгөөний хүчийг илэрхийлэгч RSI индекс 30-тай ойр буюу **доод интервалдаа ойртсон нь авах цэг ойртсоныг харуулна.**
- 2013 оноос хойшхи урт хугацааны дэмжлэгийн бүс 9.3-10.4 HKD-д байна.

Хувьцааны ханшийн өсөлтөд нөлөөлөх суурь хүчин зүйлс:

- Компанийн P/S харьцаа 0.4, P/E харьцаа 9.2 байгаа нь салбарын дунджаас тус тус 3.0х, 6.0х дахин бага байна.
- Компанийн үнэ ашгийн харьцаа P/E нь 9.2 байгаа нь өөрийн 5 жилийн дундаж харьцаанаас 28%-иар бага үзүүлэлт юм.
- БНХАУ-ын хадгаламжийн хүү 2.10% байгаа бол компанийн ногдол ашгийн өгөөж 4.15% байна.




CITIC SECURITIES
HKEX: 6030

Reuters зорилтот ханш:
HKD 16.9 (+40%)

Зөвлөмж:
Авах, Хүлээх


Хувьцааны үнэ ашгийн харьцаа:




CITIC Securities компанийн борлуулалтын орлого нь 2020-2022 онуудад КОВИД цар тахлын нөлөө, БНХАУ-ын зах зээлийн уналт, үл хөдлөх хөрөнгийн салбаруудын томоохон бондууд дефолт болсонтой холбоотой хөрөнгө оруулагчдын итгэл буурсан зэргээс шалтгаалж буурсан байна.

Харин 2023 онд бодлогын хүү буурсан нь тогтмол орлоготой үнэт цаасны андеррайтерийн орлого сэргэх гол хүчин зүйл болжээ.

Компанийн борлуулалтын орлого (тэрбум юань):



Компанийн цэвэр ашиг (тэрбум юань):





AT&T Inc
NYSE: T


Reuters зорилтот ханш:
USD 19.5 (+19%)

Зөвлөмж:
Барих

AT&T Inc. нь АНУ-ын томоохон харилцаа холбоо, технологийн компани юм. Компанийн үйл ажиллагаагаа Mobility буюу утасгүй интернетийн үйлчилгээ, Business Wireline буюу бизнесийн сүлжээ ба Consumer Wireline буюу ахуйн сүлжээ гэсэн сегментүүдэд хуваагддаг бөгөөд АНУ болон Мексикийн нутаг дэвсгэрт үйлчилгээгээ хүргэдэг.

Орлого, ашгийн үзүүлэлт

сая ам.доллараар




Нийт 27 шинжээчийн 13 нь **АВАХ**, 11 нь **БАРИХ** зөвлөмж өгч буй бөгөөд зорилтот дундаж ханш 19.51 USD байна.

Хувьцааны ханшийн техник шинжилгээ:

abilguun published on TradingView.com, Apr 11, 2024 14:39 UTC-8

AT&T Inc., 1D, NYSE 016.77 H16.79 L16.51 C16.73 -0.17 (-1.01%)





Хувьцааны ханшид нөлөөлж болзошгүй суурь хүчин зүйлс:


- АНУ-ын эдийн засаг, инфляцын түвшин ба бодлогын хүү буурах болон хэрэглэгчдийн харилцаа холбооны хэрэгцээ шаардлага нэмэгдэх нь хувьцааны ханшид эерэгээр нөлөөлнө
- Харилцаа холбооны салбарын өрсөлдөгч компаниуд болох T-Mobile, Verizon, Comcast зэрэг компаниудын үйл ажиллагаа, санал болгож буй үйлчилгээний цар хүрээ болон үнийн бодлогоос гадна Apple, Samsung компаниуд 6G системээ дотооддоо хөгжүүлж байгаа нь өрсөлдөх чадварыг бууруулсаар байна

Ногдол ашгийн өгөөжийн түвшин (ам.доллараар):


AT&T компани нь улирал тутам ногдол ашиг олгодог бөгөөд ногдол ашгийн өгөөж жилийн 6.63%-тай байна.




Балансын бүтэц сая ам.доллараар




Үйл ажиллагааны орлогын газарзүйн хуваарилалт



Сегментүүдийн үйл ажиллагааны орлогын задаргаа /сая ам.доллар/



Томоохон хувьцаа эзэмшигчдийн бүтэц





Tesla, Inc.
NASDAQ: TSLA


Reuters зорилтот ханш:
USD 188 (+7%)

Зөвлөмж:
Хүлээх, авах

Tesla, Inc. АНУ-ын Техас мужид төвтэй цахилгаан автомашин, эрчим хүч үйлдвэрлэл болон хадгалалтын тоног төхөөрөмж үйлдвэрлэдэг компани. Одоогоор Tesla дөрвөн загварын цахилгаан автомашин үйлдвэрлэдэг байна. Үүнд:

- Model 3 буюу өргөн хүрээний хэрэглэгчдэд зориулагдсан дунд оврын седан загварын цахилгаан автомашин
- Model 3 загвар дээр суурилсан бага оврын Model Y
- Дунд оврын SUV загварын Model X
- Бүрэн хэмжээний седан загварын Model S загварууд багтдаг. 2022 оны сүүлээс эхлэн Tesla Semi загварын том оврын цахилгаан автомашин үйлдвэрлэж эхэлсэн бол 2023 оны 11-р сараас эхлэн Cybertruck загварын автомашин зах зээлд нэвтэрсэн бөгөөд Tesla Roadster загварын цахилгаан автомашин хөгжүүлэлтийн шатанд явж байна.

Дэлхийн цахилгаан автомашины зах зээлд компаниудын эзлэх байр суурь:



“Нийт 49 шинжээчийн 16 нь **АВАХ**, 22 нь **БАРИХ**, 11 нь **ЗАРАХ** зөвлөмж өгч буй бөгөөд зорилтот дундаж ханш 186.88 USD байна.”

Хувьцааны ханшийн техник шинжилгээ:






Хувьцааны ханшид эерэгээр нөлөөлж болзошгүй суурь хүчин зүйлс:


- Хүү буурч зээлээрх автомашин худалдан авалт өсөх
- АНУ-ын зүүн ба баруун мужууд, БНХАУ-ын зүүн өмнөд мужуудыг холбосон автомашин цэнэглэх цахилгаан түгээгүүрийн хүртээмж нэмэгдэх
- Цахилгаан автомашин үйдвэрлэгчдийн зах зээлийн байр суурь, үнийн өрсөлдөөн буурснаар компанийн ашигт ажиллагааны үзүүлэлтүүд өсөх
- Компанийн үүсгэн байгуулагч Илон Маскийн компанийн засаглалын суурь бодлого, хөрөнгө оруулалтын шийдвэрүүдийн тогтвортой байдал

Ашгийн голлох харьцаа үзүүлэлтүүд:



Орлого, ашгийн үзүүлэлтүүд:


сая ам.доллараар




Балансын үзүүлэлтүүд (сая ам.доллар)



Борлуулалтын орлогын газарзүйн хуваарилалт



Томоохон хувьцаа эзэмшигчид



Golomt Capital[®]

Delivering diversity

Мэдэгдэл: Энэхүү мэдээлэл нь Голомт Капитал ҮЦК ХХК-иас зөвхөн мэдээллийн зорилгоор бэлтгэгдсэн болно. Тухайн мэдээ, мэдээлэл нь урьдчилан мэдэгдэлгүйгээр өөрчлөгдөж болохыг анхаарна уу. Энэхүү мэдээлэлд тулгуурлаж гаргасан аливаа шийдвэр нь хувь хүн, хуулийн этгээдийн өөрийнх нь эрсдэл болно. Тиймээс та өөрт нийцсэн хөрөнгө оруулалт эсвэл арилжаа хийхдээ бие даан шийдвэр гаргах хэрэгтэй гэдгийг анхаарна уу.

Та шинжээчидтэй холбогдох бол:
8890-9660, 9999-4110, 8806-7847

